

Нэг. ТАНЫ АНХААРАЛД

Ус Цаг Уур, Орчны Судалгаа, Мэдээллийн Хүрээлэн (УЦУОСМХ)-ийн Орчил Урсгал, Урт Хугацааны Прогнозын Судалгааны Хэлтэс (ОУУХПСХ)-ээс 2022 оны 9 – 11 дүгээр саруудын урьдчилсан төлөвийг тооцоолон танд хүргэж байна.

Урьдчилсан төлөвийг [Цаг агаар \(tsag-agaar.gov.mn\)](http://tsag-agaar.gov.mn) цахим хуудсанд сар бүрийн 28-нд шинэчлэн гаргадаг тул хэрэглэгч та бүхэн тухай бүрд нь шинэчилсэн мэдээг ашиглаж байна уу.

Дэлхийн Цаг Уурын Байгууллага (ДЦУБ)-аас тогтоосноор олонжилийн дундаж (ОЖД) утга гэдэгт 1991–2020 оны хоорондох тухайн цаг уурын хэмжигдэхүүний дундаж утгыг авч үздэг.

Улирлын төлөвийн талаар лавлах шаардлагатай бол УЦУОСМХ-ийн 11–326606 утсаар холбогдох болон тус хүрээлэнгийн ОУУХПСХ-ээс тодруулах боломжтой.

Хоёр. ТОЙМ

2.1 9 – 11 дүгээр сарын уур амьсгал

Агаарын температур IX сард Баян–Өлгий, Хөвсгөлийн ихэнх, Увс, Архангайн баруун, Завханы зүүн, Баянхонгорын хойд, Төвийн зүүн хойд хэсгээр +2...+6°C, Говь-Алтай, Баянхонгор, Өвөрхангай, Дундговийн өмнөд, Өмнөговь, Дорноговийн нутаг болон Дорнодын зүүн өмнөд хэсгээр +12...+18°C, бусад нутгаар +6...+12°C дулаан байдаг. X сард Баян–Өлгий, Хөвсгөлийн ихэнх, Увс, Архангайн баруун, Завханы зүүн, Баянхонгорын хойд, Төвийн зүүн хойд хэсгээр 0...-10°C, Говь-Алтай, Баянхонгор, Өвөрхангай, Дундговийн өмнөд, Өмнөговь баруун болон зүүн, Дорноговийн нутаг, Дорнодын зүүн өмнөд хэсгээр +4...+8°C, бусад нутгаар 0...+4°C дулаан байдаг. Харин XI сард Баян–Өлгий, Завхан, Хөвсгөлийн ихэнх нутаг, Баянхонгорын хойд, Архангайн баруун, Төвийн зүүн хойд, Хэнтийн баруун хойд хэсгээр -16...-20°C, Говь-Алтай, Баянхонгор, Өвөрхангай, Дундговийн өмнөд хэсэг, Өмнөговь, Дорноговь, Дорнодын нутгаар -2...-8°C, бусад нутгаар -8...-16°C хүйтэн байдаг байна.


Хур тунадасны хувьд IX сард Хөвсгөл, Хэнтийн уулархаг нутгаар 25–40мм, Алтайн өвөр говиор 0–5 мм, бусад нутгаар 5–25 мм хур тунадас ордог бол X сард Хэнтийн уулархаг нутгаар 12–20 мм, Их нуруудын хотгор, Алтайн өвөр говв болон говийн бүс нутгаар 0–3 мм, бусад нутгаар 3–12 мм хур тунадас ордог байна. Харин XI сард Хөвсгөл, Хэнтийн уулархаг нутгаар 6–8 мм, Их нуруудын хотгор болон говийн бүс нутгаар 0–2 мм, бусад нутгаар 2–6 мм хур тунадас ордог байна.

Гурав. 2022 ОНЫ 9 – 11 ДУГААР САРЫН УРЬДЧИЛСАН ТӨЛӨВ

3.1 2022 оны IX – XI сарын цаг агаарын мэдээ

Есдүгээр сард. Сарын дундаж агаарын температур ОЖД-аар Баян–Өлгий, Хөвсгөлийн ихэнх, Увс, Архангайн баруун, Завханы зүүн, Баянхонгорын хойд, Төвийн зүүн хойд хэсгээр +2...+6°C, Говь-Алтай, Баянхонгор, Өвөрхангай, Дундговийн өмнөд, Өмнөговь, Дорноговийн нутаг болон Дорнодын зүүн өмнөд хэсгээр +12...+18°C, бусад нутгаар +6...+12°C дулаан байдаг.


9 дүгээр сарын агаарын дундаж температур Өмнөговь, Дундговь, Дорноговийн ихэнх нутаг, Төв, Хэнтий, Сүхбаатарын өмнөд хэсгээр ОЖД-аас дулаан, бусад нутгаар ОЖД-ийн орчим байх төлөвтэй байна (**Зураг 1**).



Зураг 1. 9 дүгээр сарын агаарын температурын урьдчилсан төлөв (°C)
[H – агаарын температур ОЖД-ийн орчим, D – агаарын температур ОЖД-аас дулаан]

Сарын нийлбэр хур тунадас ОЖД–аар Хөвсгөл, Архангай, Булган, Сэлэнгийн ихэнх нутаг, Төвийн зүүн хойд, Хэнтийн хойд хэсгээр 25–50 мм, Ховд, Говь-Алтай, Баянхонгорын өмнөд, Өмнөговийн баруун хэсгээр 0–5 мм, бусад нутгаар 5–25 мм хур тунадас ордог байна.


9 дүгээр сарын нийлбэр хур тунадас Увс, Завханы зүүн хойд, Баянхонгорын хойд, Өвөрхангайн баруун, Архангай, Хөвсгөлийн ихэнх нутгаар ОЖД-аас ахиу, бусад нутгаар дунджийн орчим хур тунадас орох төлөвтэй байна (Зураг 2).



Зураг 2. 9 дүгээр сарын хур тунадасны урьдчилсан төлөв (мм)
[И – хур тунадас ОЖД-аас ахиу, Н – хур тунадас ОЖД-ийн орчим]

Аравдугаар сард. Сарын дундаж агаарын температур ОЖД-аар Баян–Өлгий, Хөвсгөлийн ихэнх, Увс, Архангайн баруун, Завханы зүүн, Баянхонгорын хойд, Төвийн зүүн хойд хэсгээр +2...+10°C, Говь-Алтай, Баянхонгор, Өвөрхангай, Дундговийн өмнөд, Өмнөговь баруун болон зүүн, Дорноговийн нутаг, Дорнодын зүүн өмнөд хэсгээр +6... +8°C, бусад нутгаар +2...+6°C дулаан байдаг.


10 дугаар сарын агаарын дундаж температур Баян-Өлгийн нутаг, Увс, Говь-Алтайн баруун, Ховдын ихэнх нутгаар ОЖД-аас хүйтэн, бусад нутгаар дунджийн орчим байх төлөвтэй байна (Зураг 3).



Зураг 3. 10 дугаар сарын агаарын температурын урьдчилсан төлөв (°C)
[Х – агаарын температур ОЖД-аас хүйтэн, Н – агаарын температур ОЖД-ийн орчим]

Сарын нийлбэр хур тунадас ОЖД-аар баруун аймгуудын баруун хойд хэсэг, төв болон зүүн аймгуудын ихэнх нутгаар 6–15 мм, бусад нутгаар 2–5 мм хур тунадас ордог байна.


10 дугаар сарын нийлбэр хур тунадас Увс, Завханы зүүн хойд, Хөвсгөлийн нутаг, Архангайн баруун хойд хэсгээр ОЖД-аас ахиу, бусад нутгаар дунджийн орчим хур тунадас орох төлөвтэй байна (Зураг 4).



Зураг 4. 10 дугаар сарын хур тунадасны урьдчилсан төлөв (мм)
 [И – хур тунадас ОЖД-аас ахиу, Н – хур тунадас ОЖД-ийн орчим]

Арваннэгдүгээр сард. Сарын дундаж агаарын температур ОЖД-аар Баян-Өлгий, Завхан, Хөвсгөлийн ихэнх нутаг, Баянхонгорын хойд, Архангайн баруун, Төвийн зүүн хойд, Хэнтийн баруун хойд хэсгээр -16...-20°C, Говь-Алтай, Баянхонгор, Өвөрхангай, Дундговийн өмнөд хэсэг, Өмнөговь, Дорноговь, Дорнодын нутгаар -2...-8°C, бусад нутгаар -8...-16°C хүйтэн байдаг байна.


11 дүгээр сарын агаарын температур нийт нутгаар ОЖД-ийн орчим байх төлөвтэй байна (**Зураг 5**).



Зураг 5. 11 дүгээр сарын агаарын температурын урьдчилсан төлөв (°C)
 [Н – агаарын температур ОЖД-ийн орчим]

Сарын нийлбэр хур тунадас ОЖД-аар Хөвсгөл, Хэнтийн уулархаг нутгаар 6–8 мм, Их нууруудын хотгор болон говийн бүс нутгаар 0–2 мм, бусад нутгаар 2–6 мм хур тунадас ордог байна.

11 дүгээр сарын нийлбэр хур тунадас нийт нутгаар ОЖД-ийн орчим байх төлөвтэй байна (**Зураг 6**).



**Зураг 6. 11 дүгээр сарын хур тунадасны урьдчилсан төлөв (мм)
[Н – хур тунадас ОЖД-ийн орчим]**

3.2 Зөвлөмж

Агаарын температур есдүгээр сард төв болон зүүн аймгуудын нутгийн өмнөд, говийн аймгуудын ихэнх нутгаар ОЖД-аас дулаан байх төлөвтэй. Аравдугаар сард баруун аймгуудын нутгийн баруун хэсгээр ОЖД-аас хүйтэн, бусад нутгаар (Алтайн уулархаг нутгаас бусад бүс нутгаар) дунджийн орчим. Арваннэгдүгээр сард нийт нутгаар ОЖД-ийн орчим байх төлөвтэй байна.

Хур тунадас ес болон аравдугаар сард Хангай, Хөвсгөлийн ууларга нутгаар ОЖД-аас ахиу орох төлөвтэй бол арваннэгдүгээр сард ихэнх нутгаар дунджийн орчим байх төлөвтэй байна.

Намрын эхэн үеэр буюу 9-10 дугаар саруудад уулархаг нутгаар ОЖД-аас ахиу хур тунадас орох төлөвтэй учир цас орж цочир хүйтрэл эрт ажиглагдах магадлалтай байгаа тул ард иргэд, аж ахуй нэгж байгууллагууд өвлийн бэлтгэл ажилдаа эртнээс анхаарна уу.